

**МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ  
ХИЙСЭН ТАЛААР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот


Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2014 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хийлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэг хийхэд Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Г.Батхүү, Ц.Оюунбаатар нар ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүд Ц.Оюунбаатар Монгол Улсын 2013 оны төсвийн зарлагын гүйцэтгэлээр Гадаад харилцааны сайдын багцад Дипломат төлөөлөгчийн газрын төсөв хэтэрч гарсныг зөвхөн валютын ханшийн зөрүүнээс болсон гэж тайлбарлах нь өрөөсгөл бөгөөд үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүгийн хариуцлага талаас нь ч авч үзэх хэрэгтэй. Мөн гадаад харилцааны үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалт сул байгаагаас яам, агентлаг, орон нутгийн төрийн байгууллагуудын үр ашиггүй, ач холбогдолгүй гадаад томилолт их байгааг Засгийн газар анхаарч, дүгнэлт хийх шаардлагатай гэсэн санал гаргасан болно.

Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэг хийсэн талаар Байнгын хорооны санал дүгнэлтийг Төсвийн зарлагын дэд хороонд хүргүүлж байна.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ц.ОЮУНБААТАР**